



БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг: jekbay01@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 89838414
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.tvet.gov.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрий аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/12/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 21-нээс 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 21-нээс 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 27-нд Бугат сумын Засаг даргын тамгын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Бугат сумын Засаг даргын тамгын газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь "Төр засгийн бодлого, шийдвэр тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт шинжилгээ, хяналт шалгалт хийж үнэлгээ өгөх, нэгтгэж тайлагнахад хяналт тавьж, удирдлагыг үр ашигтай мэдээллээр хангах, зөвлөмж дэмжлэг үзүүлэх, дүгнэлт гаргах, үр дүнг сайжруулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д "төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн аймгийн төрийн сангаар дамжуулан Бугат сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд "бага" буюу мэдээллийн технологийн

мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төв ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Бугат сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт их байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу орон нутгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын төсвийн захирагч нь 2017 онд 290,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, 24,5 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 257,9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, ОНХСангаас 17,4 сая төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 15,5 сая төгрөгийн санхүүжилт авч бүгд 290,8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулжээ.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 46,3 сая төгрөг зарцуулснаас ХХААГазраас 11,6 сая төгрөгийн, аймгийн ОБХэлтэсээс 4,0 сая төгрөгийн, статистикийн хэлтэсээс 0,6 сая төгрөгийн бүгд 16,2 сая төгрөгийг зарцуулжээ.

Үүнээс гадна Орон нутгийн төсөвт орох ан агнуурын орлогоос 30,1 сая төгрөгийг ЗДТГазрын нэмэлт төсвийн дансанд оруулан, зарцуулж, нэмэлт төсвийн гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны орон тоог 24,5 орон тоо баталсанаас 28,5 орон тоо ажиллуулж батлагдсан орон тоог 4-өөр хэтрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Бугат сумын Засаг даргын тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар хуулийн 6-р зүйлийн 6.1.3,

6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.3.5, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн 306,6 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөж, биелэлтийг 2017.12.22-ны №374 тоотой ирүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ, ХХОАТ, түлш халаалт, тээвэр шатахуун, МЭҮЗардал, гэрэл цахилгаан зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3.1/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 40,0-50,0 хувь нь хамрагдсан болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа зөрчил илэрсэн.Үүнд:

1. “Монгол Сафари” ХХК-наас орсон 30111.5 мянган төгрөгийн сумын орон нутгийн төсвийн орлогод орох ангийн орлогыг ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж, Засаг даргын захирамжаар шууд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.6.1 "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 6.6.2-т "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.6.4-д "төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 23.8-д "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.8.4-д "агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах",

41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр болов.*

2.3ДТГазар нь оны эцэст 9,3 сая төгрөгийн авлагатай гарч оны эхнээс 4.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, НДШ, ХХОАТатварт 6.4 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн. 2017 онд ажиллагсадад урьдчилгааг хяналтгүй олгож, урьдчилгааны тооцоог бүрэн хийгээгүй, 4871.8 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Суутгаагүй урьдчилгааг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, авлага, өглөгийг барагдуулж, төсвийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг албан шаардлагаар үүрэг болгов.*

3.Тайлант онд худалдан авсан 17943.8 мянган төгрөгийн тээвэр шатахууны анхан шатны баримтуудыг бүрдүүлээгүй, зарцуулалтын тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй, зардлын дансанд шууд бүртгэж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14-р зүйлийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 20-р зүйлийн 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах", 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчил арилгуулахаар албан шаардлага өгөв.*

4. Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны орон тоог удирдах ажилтан 7, гүйцэтгэх ажилтан 10, үйлчилэх ажилтан 2.5, гэрээт 5 бүгд 24,5 орон тоо баталсанаас 2017 онд шинээр 1 дотоод ажил хариуцсан ТҮ-1-1 шатлалаар, 1 аж ахуй үйчилгээний болон гэрээт ажилдчыг хариуцсан эрхлэгчийг ТҮ-5-2 шатлалаар, 2 галч гэрээтээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж, бүгд 28,5 орон тоо ажиллуулж батлагдсан орон тоог 4-өөр хэтрүүлэн ажиллуулсан.

Шийдвэрлэсэн нь: *Батлагдсан орон тооны хязгаарыг баримталж, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөгдөв.*

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцоололыг гүйцэд даган мөшгин шалгах боломжгүй байна. Үүнд:

1. Орон тоо болон цалин хөлс, тээвэр шатахууны зардал, орон нутгийн орлогын зарцуулалт, нөөц хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг цаг хугацааны шахуу байдлаас үүдэн түүврийн аргаар үзсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар нарийвчлан шалгах шаардлагатай.

2. Үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого хийх боломж гараагүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар хөрөнгийг биет ажиглалтаар тоолох шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Бугат сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох

бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2018.03.05